



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2026 оны 05 дугаар сарын 22
№20 (1415)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | | |
|-----|---|--|-----|
| 66. | Монгол Улсын Их Хурлын чуулганы
хуралдааны дэгийн тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай | | 939 |
|-----|---|--|-----|

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|-----|--|-----------|-----|
| 67. | Хуулийн төсөл буцаах тухай | Дугаар 13 | 940 |
| 68. | Хуулийн төсөл буцаах тухай | Дугаар 14 | 942 |
| 69. | Хуулийн төсөл буцаах тухай | Дугаар 16 | 944 |
| 70. | Дэд хорооны бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай | Дугаар 19 | 946 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|-----|--|-----------|-----|
| 71. | Өвчний хяналт, сэргийлэлтийн үндэсний
төв байгуулах, дүрэм батлах тухай | Дугаар 52 | 948 |
|-----|--|-----------|-----|



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр
сарын 24-ний өдөр

Дугаар 13

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.14 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүнээс 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Онц байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

С.БЯМБАЦОГТ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.14 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Х.Ганхуяг нараас 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

С.БЯМБАЦОГТ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 05 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар 16

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.14 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, А.Ариунзаяа, Х.Баасанжаргал, Б.Баярбаатар, Э.Болормаа, О.Саранчулуун, Ч.Номин, О.Номинчимэг нараас 2026 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

С.БЯМБАЦОГТ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 05 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 19

Улаанбаатар
хот

Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.9 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаярыг Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлсүгэй.

2. Монгол Улсын Их Хурлын гишүүн Сүрэнжавын Лүндэгийг Тусгай хяналтын дэд хорооны гишүүнээр баталсугай.

3. Энэ тогтоолыг 2026 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

С.БЯМБАЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны 02 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 52

Улаанбаатар
хот

Өвчний хяналт, сэргийлэлтийн үндэсний төв байгуулах, дүрэм батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, Иргэний хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 31.5 дахь хэсэг, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын хэмжээнд хүн амын эрүүл мэнд, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хариу арга хэмжээ авах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх, өвчний хяналт, сэргийлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг бүхий Өвчний хяналт, сэргийлэлтийн үндэсний төвийг Эрүүл мэндийн яамны харьяанд байгуулсугай.

2. Өвчний хяналт, сэргийлэлтийн үндэсний төвийн дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

3. Өвчний хяналт, сэргийлэлтийн үндэсний төвд эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийг нийлүүлж, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн тандалт судалгаа, нийгмийн эрүүл мэндийн лабораторийн 204 албан хаагчийн орон тоо, төсөв, эд хөрөнгийг шилжүүлж, тус төвийн орон тооны дээд хязгаарыг 425 байхаар тогтоосугай.

4. Өвчний хяналт, сэргийлэлтийн үндэсний төвийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг баталж, 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс үйл ажиллагааг эхлүүлэх, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлахыг Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэнд даалгасугай.

5. Өвчний хяналт, сэргийлэлтийн үндэсний төвийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэнд даалгасугай.



6.Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төв болон Халдварт өвчин судлалын үндэсний төвийн тандалт судалгаа, нийгмийн эрүүл мэндийн лабораторийн эд хөрөнгийг Өвчний хяналт, сэргийлэлтийн үндэсний төвд шилжүүлэх ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус үүрэг болгосугай.

7.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэнд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Г.ЗАНДАНШАТАР

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Ж.ЧИНБҮРЭН



Засгийн газрын 2026 оны 02 дугаар
сарын 11-ний өдрийн 52 дугаар
тогтоолын хавсралт

ӨВЧНИЙ ХЯНАЛТ, СЭРГИЙЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Өвчний хяналт, сэргийлэлтийн үндэсний төв (цаашид “Төв” гэх) нь хүн амын эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах, өвчний хяналт, сэргийлэлтийн чиглэлээр нийгмийн эрүүл мэндийн цогц арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, мэргэжил, арга зүйгээр хангах, үйл ажиллагааг уялдуулж удирдан зохицуулах чиг үүрэг бүхий нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан үндэсний төв байгууллага мөн.

1.2.Төв нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ дүрмийг удирдлага болгоно.

1.3.Төвийн оноосон нэр “Өвчний хяналт, сэргийлэлтийн үндэсний төв” буюу “ӨХСҮТ” гэж товчилно.

1.4.Төвийн оршин байгаа газар, шуудангийн хаягийг төвийн удирдлага байршиж байгаа газрын хаягаар тодорхойлно.

1.5.Төв нь холбогдох журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд өөрийн бэлгэдэлтэй байж болно. Бэлгэдлийн загварыг Төвийн Ерөнхий захирал батална.

Хоёр.Төвийн удирдлага, чиг үүрэг

2.1.Төвийн өдөр тутмын үйл ажиллагааг Ерөнхий захирал удирдах ба эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

2.2.Төвийн өдөр тутмын болон шуурхай үйл ажиллагааны талаар Ерөнхий захиралд зөвлөх үүрэг бүхий Удирдлагын зөвлөл байнгын болон түр хороо, зөвлөлийг тус тус ажиллуулж болно. Зөвлөл хорооны ажиллах журмыг Ерөнхий захирал батална.

2.3.Төв нь хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар хууль тогтоомжид заасан хугацаанд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тайлагнана.

2.4.Төв нь Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 12 дугаар зүйлд зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.4.1.халдварт болон халдварт бус өвчний нэгдсэн тандалтын тогтолцоог хөгжүүлэх, олон эх сурвалжит тандалт хийх, тандалтын их өгөгдөлд дүн шинжилгээ хийж бодлого, хөтөлбөр, арга хэмжээг нотолгоонд суурилан төлөвлөж хэрэгжүүлэх;

2.4.2.нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааг нотолгоо, судалгаа болон зан үйлийн өөрчлөлтийн онолд тулгуурлан зохион байгуулах, хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, халдварт болон халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах чиглэлээр хувь хүн, гэр бүл, иргэний нийгэм, олон нийтийн оролцоонд тулгуурласан арга хэмжээг зохион байгуулах;

2.4.3.зоонозын болон анзаарагддаггүй халдварт өвчний байгалийн голомт, хүн амын дундах тархалт, идэвхжлийг судалж, хяналт, сэргийлэлтийн цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;

2.4.4.дархлаажуулалт бүхий халдварт өвчний тандалт, хяналт, сэргийлэлтийн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх, дархлаажуулалтын үр дүнг үнэлэх, вакцины хэрэгцээ, нөөц, хуваарилалт, хадгалалт, тээвэрлэлт, аюулгүй байдлыг хангах;

2.4.5.нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах, шуурхай хариу арга хэмжээг үндэсний хэмжээнд удирдан зохион байгуулах, олон эх сурвалжит тандалтын мэдээллийг бодит хугацаанд (24/7) нэгтгэх, дүн шинжилгээ хийх, эргэн мэдээлэх, Улсын онцгой комисс, Эрүүл мэндийн яам, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах, Шуурхай удирдлагын төв, нэгжийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, зохицуулах;

2.4.6.халдварт болон зоонозын өвчин, хүрээлэн буй орчин, хүнс, хоол тэжээл болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх, лабораторийн шинжилгээ хийх, өсгөврийн сан бүрдүүлж био аюулгүй байдлыг хангах, нийгмийн эрүүл мэндийн лабораторийн сүлжээг удирдан зохион байгуулах, чанарын хяналтын болон лавлагаа лабораторийн тусламж, үйлчилгээ үзүүлэх;

2.4.7.нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр эрдэм шинжилгээний ажил хийх, инновац, шинэ технологи нэвтрүүлэх;

2.4.8.салбарын их өгөгдлийг нэгтгэн ашиглах, дэвшилтэт технологи болон хиймэл оюун ухаанд суурилсан шийдлийг нэвтрүүлэх замаар нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үр дүн, үр



өгөөж, нөлөөллийг үнэлэх, хүн амын эрүүл мэндийн байдал, өвчлөлийн чиг хандлагыг тодорхойлох, цаашдын эрсдэлийг урьдчилан таамаглах мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх;

2.4.9.нийгмийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, төгсөлтийн дараах болон талбарын тархвар судлалын сургалтын үйл ажиллагаа эрхлэх;

2.4.10.нийгмийн эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт, санхүүжилтийн төлөвлөлт хийх, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багц, төлбөрийн аргыг баримтлан ажиллах;

2.4.11.Монгол Улсын гадаад бодлоготой уялдуулан гадаад улс, бүс нутгийн болон олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, хил дамнасан өвчний эрсдэл болон олон улсын эрүүл мэндийн аюулгүй байдлыг бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;

2.4.12.орон нутаг дахь нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллагын хөгжлийг дэмжих, мэргэжлийн удирдлагаар хангах.

Гурав.Төвийн эрх, үүрэг

3.1.Төв нь Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт зааснаас гадна дараах эрхтэй байна:

3.1.1.өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа үл хөдлөх, хөдлөх болон бусад эд хөрөнгийг энэ дүрэмд заасан үйл ажиллагааны үндсэн чиглэлд нийцүүлэн эзэмших, ашиглах;

3.1.2.төв нь чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний болон материаллаг нөөц, төсвийг бүрдүүлж, холбогдох хууль тогтоомж, журам, дүрмийн дагуу захиран зарцуулах, хөрөнгө оруулалтын асуудлаар төрийн захиргааны төв байгууллагад санал тавьж, шийдвэрлүүлэх;

3.1.3.үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран хурал, зөвлөгөөн, сургалт, семинар зохион байгуулах, ном товхимол, эмхэтгэл, зөвлөмж гаргах, нийтийн хүртээл болгох;

3.1.4.гадаад, дотоодын ижил түвшний байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, судалгаа хийх, туршлага солилцох асуудлаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр гэрээ, хэлэлцээр, санамж бичиг байгуулах;

3.1.5.нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед салбар хоорондын оролцоотой хийсэн эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн хариу арга хэмжээг төлөвлөж, шийдвэр гаргах, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах;

3.1.6.хууль тогтоомжид заасан бусад эрх.

3.2.Төв нь Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт зааснаас гадна дараах үүрэгтэй байна:

3.2.1.төв нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг үндэслэл, тооцоо судалгаанд тулгуурлан боловсруулах, батлагдсан төсөв, орон тооны хязгаарт багтааж байгууллагын үйл ажиллагааг зохион байгуулах, санхүү, төсвийн нээлттэй, ил тод зарчмыг баримтлан Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Шилэн дансны тухай хуулиуд болон холбогдох хууль тогтоомжийг мөрдөж хэрэгжүүлэх;

3.2.2.төрийн өмчийг үрэгдүүлэх, үнэгүйдүүлэх, чанар байдлыг доройтуулах зэрэг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, бүртгэл, ашиглалтад хяналт тавих, үр ашгийг дээшлүүлэх;

3.2.3.албан хаагчдын нийгмийн баталгаа тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах, мэргэжил, ур чадварт тохирсон цалин хөлс олгох, ажлын бүтээмж, үр дүнд суурилсан урамшуулал олгох, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, сургалтад хамруулах;

3.2.4.албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, сахилга, хариуцлагыг сайжруулах, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хэм хэмжээг мөрдүүлэх, хэвшил болгох арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх;

3.2.5.төв нь үйл ажиллагаандаа авлига авах, өгөх, албан тушаалын байдлаа аливаа хэлбэрээр урвуулан ашиглах, хууль бус үйлдэл, үйл ажиллагааг хориглох, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах;

3.2.6.жендэрийн тэгш байдлыг хангах, бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалт, ажлын байрны дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.2.7.тусгай хэрэгцээт иргэний эрхийг хүндэтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, мэдээлэл авах, бусадтай харилцахад шаардлагатай орчин нөхцөлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэх;

3.2.8.хувь хүн, гэр бүл, хамт олонд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих орчныг бүрдүүлэх;

3.2.9.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

**Дөрөв.Төвийн санхүүжилт, санхүүгийн
тайлан, бүртгэл**

4.1.Төвийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

4.1.1.улсын төсөв;

4.1.2.хандив, өөрийн үйл ажиллагааны орлого, гадаадын зээл тусламж, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

4.2.Төв нь төсөв, санхүүгийн үр ашигтай удирдлагыг нутагшуулж, эрсдэлийг бүрэн тооцож, өр, авлагагүй ажиллана.

4.3.Төв нь өөрийн эд хөрөнгийг бүрэн бүтэн байдлыг хангаж, үндсэн хөрөнгө бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, актлах саналаа холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

4.4.Төвийн эд хөрөнгийн тооллогыг холбогдох хууль тогтоомжийн дагуу тогтсон хугацаанд явуулна.

4.5.Төв нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу зохион байгуулж, санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийлгэж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллана.

Тав.Бусад

5.1.Төв нь албан хэрэг хөтлөлт, цахимжуулалт, архивын баримт бичгийн хадгалалт, хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжүүлнэ.

5.2.Төв нь дотоод хяналтын тогтолцоог холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлж, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, санхүүгийн сахилга батыг ханган ажиллана.

---oOo---

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.25

Индекс: 200003

